



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2015 ОНЫ 2 ДУГААР
УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ
2015 оны 8 дугаар сар

ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА

З. НАРАНТУЯА

ДЭД ДАРГА

Х. БУМ-ЭРДЭНЭ

ДЭД ДАРГА

Э. БАТБОЛД

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Б.БАТСЭЛЭНГЭ

ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Ц.НАЦАГДОРЖ

ДААТГАЛЫН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЖАВХЛАНТ

БОЛОВСРУУЛСАН:

ДААТГАЛЫН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ХЯНАН ШАЛГАГЧ

Ц.ДАШНЯМ

ГАРЧИГ

1. ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ	3
1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
1.2. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ	4
1.3. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	6
1.4. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО	7
1.5. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР	10
1.6. ДААТГАЛЫН НӨӨЦ САН	12
1.7. ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА	12
1.8. ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА	15
1.9. ДАВХАР ДААТГАЛ	15
1.10. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ	16
2. ЕРДИЙН ДААТГАЛ	17
2.1. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ	17
2.2. ЕРДИЙН ДААТГАГЧДИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	17
2.3. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО	18
2.4. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР	18
2.5. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА	19
2.6. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ	20
3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ²¹	
3.1. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ	21
3.2. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР	22
3.3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ	22
3.4. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА	23
4. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ	24
5. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ	25
5.1. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ	25
5.2. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	26
6. ДҮГНЭЛТ, САЛБАРЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ	27

1. ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2015 оны 2 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 16, урт хугацааны даатгалын 1, хөдөө аж ахуйн давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 33, даатгалын хохирол үнэлэгч 21 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн салбар болон төлөөлөгчийн газар 258, даатгалын зуучлагч компанийн 171 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 52 салбар Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нь арилжааны даатгалын борлуулалтын сувгийг нэмэгдүүлж, иргэдэд хүрэх даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж байна.

Ердийн даатгалын компаниудаас “Монгол даатгал” ХХК гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, “Ард даатгал” ХХК, “Ган зам даатгал” ХХК-иуд хамтарсан хөрөнгө оруулалттайгаар, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компани Засгийн газрын 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт -1

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№		2009	2010	2011	2012	2013	2014.II	2015.II
1	Ердийн даатгалын компани	17	16	16	17	16	16	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1	1	1	1	1	1
3	Давхар даатгалын компани							1
4	Даатгалын төлөөлөгч	1676	2061	2057	2357	3187	3171	3210
5	Даатгалын зуучлагч	5	9	8	17	20	24	33
6	Даатгалын хохирол үнэлэгч	2	6	9	9	14	17	23
7	Актуарч	10	12	13	18	15	15	15
	БҮГД	1711	2105	2104	2419	3253	3244	3298

Хүснэгт-2

Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо

№		2013	2014	2015.II
1	Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар	251	254	258
2	Даатгалын зуучлагч компанийн салбар	64	135	171
3	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар	8	42	52
	БҮГД	323	431	481

2015 оны 2-р улирлын байдлаар: Хорооны 2015 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 44, 45 дугаар тогтоолоор “Түвшин ориент” ХХК, “Мастер шийдэл” ХХК-иуд, 2 дугаар сарын 25-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор “Цагаан гэрэлт” ХХК, 3 дугаар сарын 11-ний өдрийн 125 дугаар тогтоолоор “Арм интернэшнл” ХХК, 5 дугаар сарын 20-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор “Эл би жи брокерэж” ХХК тус тус даатгалын зуучлалын чиглэлээр, 2015 оны 1 дүгээр 21-ний өдрийн 48 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК давхар даатгалын чиглэлээр, 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 98 дугаар тогтоолоор “Кости эстимэйт” ХХК, 4 дүгээр сарын 10-ний өдрийн 200, 201 дүгээр тогтоолуудаар “Хас үнэлгээ” ХХК, “Хөрөнгө эстимэйт” ХХК-ууд даатгалын хохирол үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа

явуулах тусгай зөвшөөрөл авсан бол “Моннис даатгал” ХХК хувь нийлүүлэгчдийн шийдвэрээр татан буугдахаар шийдвэрлэгдэж, Хорооны 2015 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 307 дугаар тогтоолоор тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

1.2. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 2015 оны 2 дугаар улиралд 170.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.9 тэрбум төгрөгөөр буюу 24.8 хувиар өссөн байна. 2015 оны 2 дугаар улиралд гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ нийт даатгалын компанийн хөрөнгийн 25.3 хувийг эзэлж байна.





График-2

Салбарын нийт хөрөнгөд эзлэх хувь



Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ

№	Даатгалын компани	Нийт хөрөнгийн хэмжээ			Даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээний салбарт эзлэх хувь
		Эргэлтийн хөрөнгө	Эргэлтийн бус хөрөнгө	Хөрөнгө	
1	Монре даатгал	4,682,290,466.02	820,186,574.03	5,502,477,040.05	3.23%
2	Ард даатгал	7,180,182,609.08	1,315,565,549.73	8,495,748,158.81	4.98%
3	Бодь даатгал	8,955,161,903.49	2,634,841,810.32	11,590,003,713.81	6.79%
4	Мөнх даатгал	3,182,706,238.00	1,089,164,710.00	4,271,870,948.00	2.50%
5	Миг даатгал	8,715,036,349.78	2,139,098,717.08	10,854,135,066.86	6.36%
6	Соёмбо даатгал	6,693,993,008.82	2,605,506,894.28	9,299,499,903.10	5.45%
7	Монгол даатгал	20,478,462,619.05	9,437,995,557.61	29,916,458,176.66	17.54%
8	Тэнгэр даатгал	11,047,976,808.45	1,182,297,391.23	12,230,274,199.68	7.17%
9	Номин даатгал	7,943,471,655.44	0.00	7,943,471,655.44	4.66%
10	Улаанбаатар хотын даатгал	4,125,079,913.65	1,492,970,789.31	5,618,050,702.96	3.29%
11	Гэр даатгал	4,595,129,593.21	46,891,632.25	4,642,021,225.46	2.72%
12	Ган зам даатгал	4,680,017,594.68	23,965,120.40	4,703,982,715.08	2.76%
13	Практикал даатгал	7,321,158,999.08	1,408,960,757.71	8,730,119,756.79	5.12%
14	Мандал женерал даатгал	8,831,517,074.18	571,642,054.56	9,403,159,128.74	5.51%
15	Хаан даатгал	5,721,985,780.30	915,189,128.61	6,637,174,908.91	3.89%
16	Нэшнл лайф	3,965,043,946.58	2,702,748,078.52	6,667,792,025.10	3.91%
17	ХАА-н давхар даатгал	23,873,927,937.39	226,015,876.55	24,099,943,813.94	14.13%
	НИЙТ	141,993,142,497.20	28,613,040,642.19	170,606,183,139.39	100.00%

Эргэлтийн хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 83.4 тэрбум төгрөгийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, 21.3 тэрбум төгрөгийн богино хугацаатай хөрөнгө оруулалт, 18.9 тэрбум төгрөгийн дансны авлага, 18.4 тэрбум төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгө байна. Эргэлтийн хөрөнгө нийт дүнгээрээ өмнөх оны мөн үеэс 21.8 тэрбум төгрөгөөр буюу 18.1 хувиар өссөн байна.

Хүснэгт-4


Эргэлтийн хөрөнгийн бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2014.II		2015.II		Өөрчлөлт	
	төгрөгөөр	Эзлэх хувь	төгрөгөөр	Эзлэх хувь	төгрөгөөр	хувиар
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	66.70	55.49%	83.40	58.73%	16.70	25.01%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	28.00	23.29%	21.30	15.00%	-6.70	-23.92%
Дансны авлага	21.40	17.77%	18.90	13.33%	-2.40	-11.35%
Бусад эргэлтийн хөрөнгө	4.10	3.44%	18.40	12.93%	14.20	343.51%
Эргэлтийн хөрөнгийн дүн	120.20	100.00%	141.99	100.00%	21.80	18.13%

Эргэлтийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөг/


График-3



1.3. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2015 оны 2 дугаар улирлын даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөр 3.6 тэрбум төгрөгөөр буурсан, нөөц сан 9.5 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 27.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Өмнөх оноос хамгийн их буюу 45.6 хувиар өссөн эзэмшигчдийн өмчийн өсөлтөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн эзэмшигчдийн өмчийн хэмжээ нөлөөлсөн байна.

График-4



Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, өр төлбөр, эзэмшигчдийн өмчийн эзлэх хэмжээг сүүлийн 5 жилийн 2 дугаар улирлын байдлаар харьцуулсан. Мөн хүснэгт 5, 6-д дэлгэрэнгүй байдлаар харуулав.

Үзүүлэлтүүд	2014.II		2015.II		Өөрчлөлт	
	төгрөгөөр	эзлэх хувь	төгрөгөөр	эзлэх хувь	төгрөгөөр	хувиар
Өр төлбөр	10,750,602,281.63	7.86%	7,155,794,346.16	4.19%	-3,594,807,935.47	-33.44%
Нөөц сан	64,697,608,689.43	47.31%	74,237,330,588.37	43.51%	9,539,721,898.94	14.75%
Эзэмшигчийн өмч	61,290,551,126.51	44.82%	89,213,058,204.86	52.29%	27,922,507,078.35	45.56%
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	136,738,762,097.57		170,606,183,139.39		33,867,421,041.82	24.77%

Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Компани	Өр төлбөр		Эзэмшигчдийн өмч	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	Эзлэх хувь
	Өр төлбөр	Нөөц сан			
Монре даатгал	117,180,467.91	1,684,660,855.98	3,700,635,716.16	5,502,477,040.05	3.2%
Ард даатгал	308,200,485.35	3,887,422,566.56	4,300,125,106.90	8,495,748,158.81	5.0%
Бодь даатгал	417,132,535.74	7,161,736,779.18	4,011,134,398.89	11,590,003,713.81	6.8%
Мөнх даатгал	9,161,257.00	553,929,272.00	3,708,780,419.00	4,271,870,948.00	2.5%
Миг даатгал	233,465,060.92	6,090,274,499.00	4,530,395,506.94	10,854,135,066.86	6.4%
Соёмбо даатгал	363,379,353.92	3,991,484,560.08	4,944,635,989.10	9,299,499,903.10	5.5%
Монгол даатгал	2,195,106,980.99	17,999,616,467.67	9,721,734,728.00	29,916,458,176.66	17.5%
Тэнгэр даатгал	881,004,594.72	6,564,672,603.32	4,784,597,001.64	12,230,274,199.68	7.2%
Номин даатгал	85,550,093.52	4,360,269,286.50	3,497,652,275.42	7,943,471,655.44	4.7%
Улаанбаатар хотын даатгал	6,735,825.55	1,692,264,218.00	3,919,050,659.41	5,618,050,702.96	3.3%
Гэр даатгал	32,121,696.62	841,480,392.05	3,768,419,136.79	4,642,021,225.46	2.7%
Ган зам даатгал	101,950,826.57	742,378,228.13	3,859,653,660.38	4,703,982,715.08	2.8%
Практикал даатгал	173,711,900.11	4,267,846,177.10	4,288,561,679.58	8,730,119,756.79	5.1%
Мандал женерал даатгал	2,012,818,520.80	3,044,254,320.16	4,346,086,287.78	9,403,159,128.74	5.5%
Хаан даатгал	76,924,608.41	2,953,430,660.25	3,606,819,640.25	6,637,174,908.91	3.9%
Нэшнл лайф	16,672,189.68	1,401,609,702.39	5,249,510,133.03	6,667,792,025.10	3.9%
ХАА-н давхар даатгал	124,677,948.35	7,000,000,000.00	16,975,265,865.59	24,099,943,813.94	14.1%
НИЙТ	7,155,794,346.16	74,237,330,588.37	89,213,058,204.86	170,606,183,139.39	100.0%


1.4. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацааны даатгалын салбарын нийт хураамжийн орлого 65.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.16 дахин өссөн бөгөөд нийт хураамжийн 60 хувь буюу 38.3 тэрбум төгрөгийг даатгалын цэвэр хураамжид тооцсон байна. Даатгалын нийт хураамжийн орлогын 99.8 хувь буюу 65.2 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.2 хувь буюу 0.79 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани төвлөрүүлж, даатгалын нийт гэрээний үнэлгээ 36 их наяд төгрөгт хүрсэн байна. Даатгалын компаниудаас хамгийн их даатгалын хураамж буюу 20.3 тэрбум төгрөгийг “Бодь даатгал” ХХК, 14 тэрбум төгрөгийг “Монгол даатгал” ХХК тус тус төвлөрүүлсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалттай 3 компанийн нийт

хураамжийн орлого 18.5 тэрбум төгрөг болж салбарын хэмжээнд хураамжийн орлогын 28 хувийг бүрдүүлжээ.

Даатгалын нийт хураамжийн орлого
/тэрбум төгрөг/

График-5



Хүснэгт-7

Даатгалын хураамжийн орлого

Даатгалын компани	Даатгалын нийт хураамжийн орлого /сая төгрөг/	Давхар даатгалын хураамж /сая төгрөг/	Буцаасан даатгалын хураамж /сая төгрөг/	Даатгалын цэвэр хураамжийн орлого /сая төгрөг/
Монре даатгал	1,381.0	24.9	38.2	1,317.9
Ард даатгал	4,393.4	741.5	57.3	3,594.5
Бодь даатгал	20,362.5	15,284.0	105.1	4,973.4
Мөнх даатгал	311.8	0.0	0.0	311.8
Миг даатгал	5,284.6	243.8	106.9	4,933.9
Соёмбо даатгал	3,068.2	229.8	185.2	2,653.2
Монгол даатгал	14,026.7	5,637.8	88.0	8,301.0
Тэнгэр даатгал	4,162.1	747.7	95.7	3,318.6
Номин даатгал	2,093.8	167.0	33.4	1,893.4
Улаанбаатар хотын даатгал	927.8	0.0	0.5	927.3
Гэр даатгал	209.2	0.0	0.6	208.6
Ган зам даатгал	96.8	0.0	0.3	96.5
Практикал даатгал	2,726.0	291.2	59.1	2,375.7
Мандал женерал даатгал	3,723.8	2,653.2	40.5	1,030.2
Хаан даатгал	2,419.6	0.0	15.1	2,404.5
Нэйшнл лайф	796.7	5.0	0.0	791.7
Дүн	65,984.1	26,025.9	826.1	39,132.1

Тайлант хугацааны даатгалын нийт хураамжийн 77.1 хувийг 4 төрлийн бүтээгдэхүүний орлого бүрдүүлжээ. Орлогын бүтцээс үзэхэд нийт орлогын 22.5 хувийг хөрөнгийн даатгал, 19.5 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 13 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 22 хувийг агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгалын орлого тус тус эзэлж байна.


Хүснэгт-8

№	Даатгалын хэлбэр	Даатгалын нийт хураамжийн орлого		Өөрчлөлт /дахин/
		2014.06.30	2015.06.30	
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	4,774,078,794.56	5,672,338,873.88	1.19
2	Хөрөнгийн даатгал	15,065,206,298.60	14,841,561,654.87	0.99
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	10,220,902,780.75	8,586,339,944.66	0.84
4	Ачааны даатгал	1,224,794,196.08	547,247,254.11	0.45
5	Барилга угсралтын даатгал	828,497,994.62	707,919,344.91	0.85
6	Газар тариалангийн даатгал	0.00	0.00	
7	Мал амьтдын даатгал	190,161,373.46	142,449,786.83	0.75
8	Агаарын хөлгийн даатгал	4,093,598,148.58	2,216,406,441.48	0.54
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	2,028,329,148.32	212,871,886.78	0.10
10	Хариуцлагын даатгал	2,904,001,671.19	2,402,631,274.52	0.83
11	Санхүүгийн даатгал	1,280,719,348.69	1,891,470,652.62	1.48
12	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	10,412,202,979.47	12,881,921,866.81	1.24
13	Зээлийн даатгал	1,322,683,201.07	420,452,060.41	0.32
14	Итгэлцлийн даатгал	54,263,476.00	43,540,914.00	0.80
15	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	0.00	50,000.00	
16	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	1,965,149,291.51	14,593,219,088.18	7.43
17	Хугацаат амьдралын даатгал	147,610,427.88	191,877,874.30	1.30
18	Хуримтлалын даатгал	53,405,934.00	49,172,423.53	0.92
19	Тэтгэврийн даатгал	30,799,773.01	24,895,293.41	0.81
20	Эрүүл мэндийн даатгал	473,542,267.35	530,753,802.75	1.12
	Нийт	57,069,947,105.14	65,984,120,438.05	1.16

Даатгалын хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг дараах графикаас үзэхэд даатгалын зуучлалын мэргэжлийн үйл ажиллагаа зах зээл дээр хамгийн бага хувийг эзэлж байна.

График-6

Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт




1.5. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2015 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 20.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон. Тайлант хугацаанд “Монгол даатгал” ХХК 5.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь хамгийн өндөр байгаа бөгөөд нийт нөхөн төлбөрийн 26.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт-9

Даатгалын компани	Нөхөн төлбөр		Өөрчлөлт /дахин/
	2014.06.30	2015.06.30	
Монре даатгал	506,131,217.00	969,832,974.00	1.92
Ард даатгал	1,496,676,111.86	2,280,956,285.90	1.52
Бодь даатгал	1,679,337,714.40	1,843,878,021.00	1.10
Мөнх даатгал	98,968,570.00	48,097,718.00	0.49
Миг даатгал	1,309,446,335.00	2,014,230,797.22	1.54
Соёмбо даатгал	867,292,988.00	816,168,898.10	0.94
Монгол даатгал	4,737,900,989.98	5,403,635,990.98	1.14
Тэнгэр даатгал	1,192,319,515.75	1,328,863,044.00	1.11
Номин даатгал	1,194,579,061.80	839,944,829.12	0.70
Улаанбаатар хотын даатгал	18,659,025.00	31,760,463.00	1.70
Гэр даатгал	47,582,764.00	40,317,143.00	0.85
Ган зам даатгал	22,920,122.00	41,477,862.00	1.81
Практикал даатгал	1,316,336,009.87	1,007,668,669.00	0.77
Мандал женерал даатгал	616,419,052.33	2,949,604,451.09	4.79
Хаан даатгал	181,333,442.00	354,619,885.00	1.96
Нэшнл лайф	276,154,708.64	465,567,088.70	1.69
НИЙТ	15,580,036,987.63	20,436,624,120.11	1.31

График-7



Даатгалын бүтээгдэхүүний хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 11589 тохиолдолд нийт 7.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, авто тээврийн хэрэгслийн даатгалын 6331 тохиолдолд 4.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон

нь хамгийн өндөр нөхөн төлбөр олгосон бүтээгдэхүүний хэлбэрт тооцогдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад барилга угсралтын даатгалын нөхөн төлбөр 25.5 дахин өссөн нь хамгийн өндөр өсөлттэй байна. Мөн авто тээврийн хэрэгслийн даатгал, ачааны даатгал, хариуцлагын даатгалын хэлбэрээр өмнөх оны мөн үеэс нөхөн төлбөр буурсан үзүүлэлттэй байна.


Хүснэгт-10

№	Даатгалын хэлбэр	2014.06.30		2015.06.30		Нөхөн төлбөрийн өөрчлөлт /дахин/
		Нөхөн төлбөр /сая төгрөг/	Нөхөн олгосон тохиолдлын тоо	Нөхөн төлбөр /сая төгрөг/	Нөхөн олгосон тохиолдлын тоо	
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1,553.75	4559	2,037.11	4250	1.31
2	Хөрөнгийн даатгал	785.93	1474	1,276.93	1618	1.62
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	4,258.10	6829	4,371.85	6331	1.03
4	Ачааны даатгал	118.62	38	98.29	12	0.83
5	Барилга угсралтын даатгал	60.21	4	1,538.32	0	25.55
6	Газар тариалангийн даатгал	0.00	0	0.00	0	-
7	Мал амьтдын даатгал	0.00	0	32.11	0	
8	Агаарын хөлгийн даатгал	94.12	3	0.00	0	-
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	4.16	25	34.78	38	8.36
10	Хариуцлагын даатгал	287.04	419	173.34	322	0.60
11	Санхүүгийн даатгал	492.94	63	1,025.80	1574	2.08
12	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	6,080.34	11776	7,305.02	11589	1.20
13	Зээлийн даатгал	1,665.00	52	2,066.39	478	1.24
14	Итгэлцлийн даатгал	0.00	0	5.10	0	
15	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	0.00	0	0.00	0	-
16	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	0.00	0	0.00	0	-
17	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	1.79	3	6.02	10	3.36
18	Хугацаат амьдралын даатгал	42.01	42	60.86	67	1.45
19	Насан туршийн даатгал	0.00	0	0.00	0	-
20	Хуримтлалын даатгал	26.86	14	38.30	22	1.43
21	Тэтгэврийн даатгал	10.88	9	20.75	6	1.91
22	Эрүүл мэндийн даатгал	196.41	522	345.66	995	1.76
23	Аннуити даатгал	0.00	0	0.00	0	-
	Дүн	15,678.16	25832	20,436.62	27312	1.30

1.6. ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Тайлант хугацаанд даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 74.2 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 12.8 хувиар өссөн боловч 6 даатгалын компанийн нөөц сан буурсан үзүүлэлттэй гарсан. Салбарын нөөц сангийн өсөлтөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн нөөц сангийн хэмжээ хүчтэй нөлөө үзүүлсэн. Салбарын хэмжээнд “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК, “Миг даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК-ууд 5 тэрбум ба түүнээс дээш төгрөгийн нөөц сантай байгаа нь нийт нөөц сангийн 60 хувийг эзэлж байна. Хорооноос даатгалын компаниудын нөөц сангийн актуар тооцооллыг хянаж байгаагаас гадна салбарын хөгжилтэй шууд хамааралтай тул сүүлийн 5 жилийн хугацааны даатгалын нөөц сангийн хэмжээний тогтмол өсөлт нь дараах графикаас харагдаж байна.


График-8



1.7. ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Даатгалын компанийн хохирол нөхөлтийн харьцаа нь даатгалын андеррайтингийг илтгэдэг гол үзүүлэлтүүдийн нэг юм. Тайлант хугацаанд төлсөн нийт нөхөн төлбөрийг орлогод тооцсон хураамжид харьцуулан хохирлын харьцааг тооцдог. Тайлант хугацаанд салбарын хэмжээнд хохирлын харьцаа нь 32.5 хувьтай байна. Энд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно. Мөн даатгалын компаниудын хувьд даатгалын цэвэр хураамжийн орлого, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 48.9 хувь, даатгалын компани тус бүрээр авч үзвэл “Монре даатгал” ХХК-ийн хохирлын харьцаа 80.8 хувь байгаа нь хамгийн өндөр, “Улаанбаатар хотын даатгал” ХХК хамгийн бага буюу 6.08 хувийн хохирлын харьцаатай байна. Салбарын хэмжээнд хохирол нөхөлтийн харьцаа зохих түвшинд байгаа хэдий ч даатгалын компаниудын зардлын харьцаа нилээд өндөр үзүүлэлттэй гарч байгаа нь зардлын болон хохирол нөхөлтийн хосолсон харьцаа өндөр гарахад хүргэж байна. Зардлын харьцааг авч үзвэл салбарын дундаж нь 63 хувь, хамгийн бага нь 48 хувь, хамгийн их нь 126.6 хувьтай байгаа нь хохирлын харьцаанаас харьцангуй өндөр байгааг илэрхийлнэ.

Даатгалын хохирол нөхөлтийн харьцаа




Даатгагчдын хохирол нөхөлтийн харьцаа

Хүснэгт-11

Багана	Даатгалын компани	Орлогод тооцсон хураамж	Даатгагчаас олгосон нөхөн төлбөр	Хохирлын харьцаа
1	Монре даатгал	1,200,786,733.49	969,832,974.00	80.8%
2	Ард даатгал	3,626,280,538.40	2,280,956,285.90	62.9%
3	Бодь даатгал	4,288,932,962.86	1,843,878,021.00	43.0%
4	Мөнх даатгал	308,653,058.00	48,097,718.00	15.6%
5	Миг даатгал	3,857,061,128.15	1,997,353,365.41	51.8%
6	Соёмбо даатгал	2,422,842,886.07	816,168,898.10	33.7%
7	Монгол даатгал	9,180,125,693.24	5,403,635,990.98	58.9%
8	Тэнгэр даатгал	3,146,013,192.16	1,302,947,821.51	41.4%
9	Номин даатгал	1,920,851,670.98	839,944,829.12	43.7%
10	Улаанбаатар хотын даатгал	522,118,270.41	31,760,463.00	6.1%
11	Гэр даатгал	152,082,609.00	40,317,143.00	26.5%
12	Ган зам даатгал	252,652,294.66	41,477,862.00	16.4%
13	Практикал даатгал	2,170,310,817.99	1,007,668,669.00	46.4%
14	Мандал генерал даатгал	1,304,451,272.85	599,895,381.31	46.0%
15	Хаан даатгал	1,881,261,609.39	354,619,885.00	18.9%
16	Нэшнл лайф	693,917,279.86	465,567,088.70	67.1%
	Нийт	36,928,342,017.51	18,044,122,396.03	48.9%

Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийг нэмж тооцсон хохирол нөхөлтийн харьцаа
Хүснэгт-12

Багана	Даатгалын компани	Орлогод тооцсон хураамж+Давхар даатгалын хураамж	Нийт нөхөн төлбөр	Хохирлын харьцаа
	1	2	3	3/2=4
1	Монре даатгал	1,225,720,648.85	969,832,974.00	79.12%
2	Ард даатгал	4,367,801,116.86	2,280,956,285.90	52.22%
3	Бодь даатгал	19,572,915,480.34	1,843,878,021.00	9.42%
4	Мөнх даатгал	308,653,058.00	48,097,718.00	15.58%
5	Миг даатгал	4,100,834,590.39	2,014,230,797.22	49.12%
6	Соёмбо даатгал	2,652,608,049.26	816,168,898.10	30.77%
7	Монгол даатгал	14,817,923,398.96	5,403,635,990.98	36.47%
8	Тэнгэр даатгал	3,893,739,940.33	1,328,863,044.00	34.13%
9	Номин даатгал	2,087,861,863.16	839,944,829.12	40.23%
10	Улаанбаатар хотын даатгал	522,118,270.41	31,760,463.00	6.08%
11	Гэр даатгал	152,082,609.00	40,317,143.00	26.51%
12	Ган зам даатгал	252,652,294.66	41,477,862.00	16.42%
13	Практикал даатгал	2,461,467,757.86	1,007,668,669.00	40.94%
14	Мандал женерал даатгал	3,957,663,590.44	2,949,604,451.09	74.53%
15	Хаан даатгал	1,881,261,609.39	354,619,885.00	18.85%
16	Нэшил лайф	698,931,675.86	465,567,088.70	66.61%
	Нийт	62,954,235,953.77	20,436,624,120.11	32.46%



1.8. ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд даатгалын компаниудын цэвэр ашиг 3.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өссөн байна. Өмнөх оны мөн үеэс 6 даатгалын компанийн цэвэр ашиг буурсан хэдий ч бусад компанийн хувьд өссөн нь нийт салбарын хувьд өсөлтийг харуулахад нөлөөлж байна. Салбарын хэмжээнд ашигт ажиллагааны түвшин өндөр өсөлттэй гарахад “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн тайлант үеийн цэвэр ашиг нь гол нөлөөлөгч хүчин зүйл болсон. Мөн урт хугацааны даатгалын компанийн цэвэр ашиг анх удаа өндөр өсөлттэй гарч байна.

Хүснэгт-13

№	Даатгалын компани	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал /сая.төг/		
		2014.06.30	2015.06.30	өөрчлөлт
1	Монре даатгал	23.31	-120.90	-144.22
2	Ард даатгал	334.39	49.80	-284.59
3	Бодь даатгал	47.92	-528.81	-576.73
4	Мөнх даатгал	2.19	52.50	50.31
5	Миг даатгал	137.40	131.07	-6.34
6	Соёмбо даатгал	-34.34	88.76	123.10
7	Монгол даатгал	-13.84	1,266.19	1,280.04
8	Тэнгэр даатгал	464.76	413.33	-51.43
9	Номин даатгал	-74.92	-34.73	40.19
10	Улаанбаатар хотын даатгал	-8.67	3.57	12.24
11	Гэр даатгал	121.87	178.41	56.54
12	Ган зам даатгал	309.71	315.05	5.34
13	Практикал даатгал	52.02	132.85	80.83
14	Мандал женерал даатгал	-288.45	-50.10	238.35
15	Хаан даатгал	127.79	79.63	-48.16
16	Нэйшнл лайф	14.43	97.72	83.30
17	ХАА-н давхар даатгал	0.00	1,192.64	1,192.64
	НИЙТ	1,215.58	3,266.98	2,051.40

1.9. ДАВХАР ДААТГАЛ


Тайлант хугацаанд малын индексжүүлсэн даатгалын давхар даатгал хийх чиг үүрэг бүхий “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь давхар даатгалын үйл ажиллагаа явуулаагүй. Харин ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд гадаадын давхар даатгагчид нийт 26 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төлсөн байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн дүнгээс 8.8 тэрбум төгрөг буюу 51 хувиар өссөн байна. Нийт даатгалын хураамжаас 40 хувийг нь давхар даатгалд төлсөн байгаа нь маш өндөр үзүүлэлт юм. “Бодь даатгал” ХХК-ийн хувьд давхар даатгалын хураамж нь нийт хураамжийн 75 хувийг, “Мандал женерал даатгал” ХХК-ийн хувьд 71 хувийг эзэлж байгаа нь нийт салбарын үзүүлэлтэд хүчтэй нөлөөлсөн. Тайлант хугацаанд давхар даатгагчаас 2.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь нийт нөхөн төлбөрийн 11.8 хувийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд салбарын хөгжлийг даган хурдацтай нэмэгдэж буй давхар даатгалын хураамжийн өсөлтийг дараах графикаар харуулав.



1.10. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

2015 оны 2 дугаар улирлын байдлаар 25 даатгалын зуучлагч компани, 8 банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын зуучлагч нар тайлант хугацаанд салбарын нийт хураамжийн орлогын 14.24 хувь буюу 9.4 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна. Даатгалын зуучлалын орлого нь өмнөх оны мөн үеэс 64 хувиар өсч 2 тэрбум төгрөгт хүрсэн.

График-12



Тайлант хугацаанд даатгалын хохирол үнэлэгч 23 компаниас 18 компани даатгалын хохирол үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж нийт 11317 удаагийн хохирлын үнэлгээ хийж, 260.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Даатгалын хохирол үнэлгээний орлого өмнөх оны мөн үеэс 10 орчим хувиар буурсан байна.


2. ЕРДИЙН ДААТГАЛ

2015 оны 2 дугаар улирлын байдлаар 15 даатгагч, даатгалын компанийн 258 салбар, төлөөлөгчийн газар Улаанбаатар хот, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

2.1. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ

Ердийн даатгалын 15 компанийн нийт хөрөнгийн хэмжээ тайлант үеийн байдлаар 139.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Сүүлийн жилүүдийн нийт хөрөнгийн тогтмол өсөлт нь даатгалын салбарын хөрөнгө оруулалт, даатгалын нийт хураамжийн орлого зэрэг санхүүгийн үзүүлэлтүүдийн өсөлттэй шууд хамааралтай юм.


График-13



2.2. ЕРДИЙН ДААТГАГЧДИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид өр төлбөр болон эзэмшигчдийн өмчийн эзлэх хувийг дараах графикаар харуулав. Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн талаар 1.3 дахь хэсэгт дэлгэрэнгүй байдлаар харуулсан.

График-14



2.3. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 16 хэлбэрийн бүтээгдэхүүнээр 65.2 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, давхар даатгалд 26 тэрбум төгрөг зарцуулж, 826 сая төгрөгийн хураамжийг даатгуулагч нарт буцаан олгосноор 38.3 тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна. Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлогын талаар 1.4 дэх хэсэгт дэлгэрэнгүй харуулсан. Ердийн даатгалын нийт хураамжийн орлогыг бүтээгдэхүүний хэлбэрээр ангилан, дараах графикаар харуулав.

График-15

Даатгалын нийт хураамжийн орлого /сая төгрөг/



2.4. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 17.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бөгөөд энэ нь салбарын нийт нөхөн төлбөрийн 97.4 хувийг эзэлж байна. Даатгалын нөхөн төлбөрийн талаар 1.5 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Мөн давхар даатгагчаар 2.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлүүлсэн бөгөөд даатгагчдийн хувьд олгосон нөхөн төлбөрийн 54 хувь буюу 9.5 тэрбум төгрөгийг даатгалын нөөц сангаас, 46 хувь буюу 8.1 тэрбум төгрөгийг орлогод тооцсон хураамжаас тус тус олгосон байна.

2.5. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА


Ердийн даатгалын компаниудаас тайлант хугацаанд “Монре даатгал” ХХК-ийн хохирлын харьцаа 80.8 хувь байгаа нь хамгийн өндөр, “Улаанбаатар хотын даатгал” ХХК хамгийн бага буюу 6.08 хувийн хохирлын харьцаатай байна. Ердийн даатгагчдын хохирлын харьцааг өмнөх оны мөн үетэй харьцуулж харуулав.

Хүснэгт-14

№	Даатгалын компани	Хохирлын харьцаа		Өөрчлөлт
		2014.06.30	2015.06.30	
1	Монре даатгал	50.0%	80.8%	30.8
2	Ард даатгал	66.0%	62.9%	-3.1
3	Бодь даатгал	37.0%	43.0%	6.0
4	Мөнх даатгал	28.0%	15.6%	-12.4
5	Миг даатгал	51.0%	51.8%	0.8
6	Соёмбо даатгал	36.0%	33.7%	-2.3
7	Монгол даатгал	50.0%	58.9%	8.9
8	Тэнгэр даатгал	42.0%	41.4%	-0.6
9	Номин даатгал	57.0%	43.7%	-13.3
10	Улаанбаатар хотын даатгал	4.0%	6.1%	2.1
11	Гэр даатгал	23.0%	26.5%	3.5
12	Ган зам даатгал	9.0%	16.4%	7.4
13	Практикал даатгал	60.0%	46.4%	-13.6
14	Мандал женерал даатгал	37.0%	46.0%	9.0
15	Хаан даатгал	16.0%	18.9%	2.9
	Дундаж	37.7%	39.5%	1.7

Тайлант хугацааны ердийн даатгалын компаниудын ашигт ажиллагааг 1.8 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Сүүлийн 5 жилийн 2 дугаар улирлын байдлаар тайлант үеийн цэвэр ашиг, хуримтлагдсан ашгийг дараах графикаар харуулав.

График-16



2.6. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нөөц сангийн 65.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.4 тэрбум төгрөгөөр буурсан байна. Ердийн даатгалын ангиллаар нөөц сан тус бүрийн дүнг дараах байдлаар харуулав.

Хүснэгт-15

Ердийн даатгалын төрөл	Даатгалын нөөц сан	2015-II
Сайн дурын даатгал	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан	25,209,641,929.86
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	8,178,691,375.25
	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	224,153,859.71
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	17,377,954,127.32
Албан журмын даатгал	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан	11,437,599,600.48
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	1,579,654,157.22
	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	38,434,009.49
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	1,789,591,826.65
	Нийт нөөцийн сан	65,835,720,885.98

График-17




График-18



Ердийн даатгалын компаниудын тайлант үеийн нийт нөөц сангийн 71 хувийг техникийн нөөц сангууд, 29 хувийг тогтвортой нөөц сан буюу УБХНС эзэлж байна.

Ердийн даатгагчид өөрт хүлээх эрсдэлийг хэсэгчлэн гадаадын давхар даатгагчид даатгуулахад тайлант хугацаанд 26 тэрбум төгрөгийн хураамжийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 51.2 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд 5 даатгалын компани давхар даатгуулаагүй байна. Давхар даатгалын талаар 1.9 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

Хүснэгт-16


№	Даатгалын компани	Давхар даатгалын хураамж		Өөрчлөлт /дахин/
		2014.06.30	2015.06.30	
1	Монре даатгал	111.31	24.93	0.22
2	Ард даатгал	2,328.13	741.52	0.32
3	Бодь даатгал	4,563.37	15,283.98	3.35
4	Мөнх даатгал	0.00	0.00	
5	Миг даатгал	449.36	243.77	0.54
6	Соёмбо даатгал	51.43	229.77	4.47
7	Монгол даатгал	6,057.83	5,637.80	0.93
8	Тэнгэр даатгал	1,303.75	747.73	0.57
9	Номин даатгал	151.48	167.01	1.10
10	Улаанбаатар хотын даатгал	0.00	0.00	
11	Гэр даатгал	0.00	0.00	
12	Ган зам даатгал	0.00	0.00	
13	Практикал даатгал	59.04	291.16	4.93
14	Мандал женерал даатгал	985.33	2,653.21	2.69
15	Хаан даатгал	129.23	0.00	0.00
	Дүн	17,187.65	26,020.88	1.51

3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

3.1. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Даатгалын салбарт “Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос хойш урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Тус компанийн хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өсөлттэй байгаа бөгөөд тайлант хугацаанд 6.7 тэрбум төгрөгт хүрсэн.


График-19



3.2. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн орлого тайлант хугацаанд 796.7 сая төгрөгт хүрч өмнөх онуудад тогтмол өсч ирсэн өсөлтийг хангасан байна. Тайлант хугацааны нөхөн төлбөр мөн өсч 465.6 сая төгрөгт хүрчээ. Урт хугацааны даатгагчийн хохирол нөхөлтийн харьцаа 67 хувьтай бөгөөд үйл ажиллагааны зардлын харьцаатай хосолсон харьцаа 130 хувьтай байна. Урт хугацааны даатгалын хураамжийн орлого салбарын хэмжээнд 1.2 хувийг эзэлж, мөн бусад санхүүгийн үзүүлэлтүүд салбарт маш бага хувийг эзэлж байна. Улс орны эдийн засгийн өсөлтийг дагаж урт хугацааны даатгал нь ердийн даатгалаас илүү хурдтай өсөх, санхүүгийн үзүүлэлтүүд нь зах зээлийн дийлэнх хувийг эзэлдэг жишиг олон улсын даатгалын салбарт ажиглагддаг. Манай улсын даатгалын салбарын цаашдын хөгжилд урт хугацааны даатгалын өсөлтийг гол нөлөөлөгч хүчин зүйл болгох зайлшгүй шаардлагатай байна.

График-20




3.3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

Давхар даатгалын хураамжид тайлант хугацаанд 5 тэрбум төгрөгийг зарцуулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Урт хугацааны даатгалын сүүлийн 5 жилийн давхар даатгалын хураамжийг графикаар харуулав.

График-20


Давхар даатгалын хураамж



3.4. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА


Урт хугацааны даатгалын хэмжээ болон хураамжийн орлогын тогтмол өсөлттэй холбоотой даатгалын нөөц сангийн хэмжээ нь тогтмол өсч байна. Тайлант хугацаанд даатгагчийн нөөц сан 1.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар өссөн байна.

График-21



“Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж эхэлснээс хойш алдагдалтай ажиллаж байсан бөгөөд 2014 оноос эхлэн ашигтай ажиллаж, 2015 оны 2 дугаар улирлын байдлаар 97.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Урт хугацааны даатгагчийн ашигт ажиллагааг сүүлийн 5 жилийн 2 дугаар улирлын байдлаар дараах графикаар харуулав.


График-22



4. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ


2015 оны 2 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “жолоочийн хариуцлагын даатгал” гэх/-ын үйл ажиллагаа эрхэлж байна. Жолоочийн хариуцлагын даатгалаар даатгалын компаниуд тайлант улиралд 12.9 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлж, өмнөх оны мөн үеэс 2.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Салбарын сүүлийн 3 жилийн нийт хураамжийн орлогыг даатгалын төрлөөр нь ангилж, тус бүрийн эзэлж буй хувийн жинг графикаар харуулав.

График-23




Тайлант хугацаанд жолоочийн хариуцлагын даатгалын 11589 тохиолдолд нийт 7.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Албан журмын болон сайн дурын даатгалын нийт хураамжийн орлого, нийт нөхөн төлбөрийг харьцуулж харуулав.

График-24



Сүүлийн 3 жилийн 2 дугаар улирлын байдлаар жолоочийн хариуцлагын даатгалын 100 гэрээ тутамд ногдож буй тохиолдлын давтамж нь дараах байдалтай байна.

График-25



5. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

5.1. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан даатгалын зуучлагчид нийт 3 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий ердийн даатгалын 11, урт хугацааны даатгалын 1 бүтээгдэхүүнийг зуучилж 9.4 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн. Даатгалын зуучлалын орлого өмнөх оны мөн үеэс 64 хувиар өсч, 2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Зуучлагч компани бүрийн зуучлалын орлогыг дараах хүснэгтэд харуулсан бөгөөд “Эрсдэлийн шийдэл” ХХК-ийн зуучлалын орлого хамгийн өндөр буюу 474 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт-17

№	Даатгалын зуучлагч компани	Даатгалын зуучлалын орлого		Өсөлт, бууралт
		2014.06.30	2015.06.30	
1	АМЕ	42,946,500.00	43,074,454.65	127,954.65
2	Ариг банк	-	30,143,502.99	30,143,502.99
3	Асимон брокерс	25,219,366.82	74,506,357.85	49,286,991.03
4	Ачит ундарга	8,917,539.16	36,834,535.41	27,916,996.25
5	Ваясню Солюшн	-	24,442,372.00	24,442,372.00
6	Гэрэлт буян ундрах	67,433,356.90	96,748,781.00	29,315,424.10
7	Капитал банк	-	31,794,909.50	31,794,909.50
8	Лоялти солюшн	125,009,468.00	109,108,613.00	-15,900,855.00
9	Мастер шийдэл	-	3,886,020.75	3,886,020.75
10	Монгол бичээч зууч	-	25,785,678.00	25,785,678.00
11	Нэйшнл эженси	16,364,323.00	36,049,894.00	19,685,571.00
12	Ренессанс групп	15,422,656.79	4,011,930.28	-11,410,726.51
13	Си эн эн икс	83,262,098.42	49,350,976.54	-33,911,121.88
14	Соёмбо Ай Би	-	462,277.50	462,277.50
15	Сүрэг хараацай	45,247,010.00	215,454,598.00	170,207,588.00
16	Төрийн банк	62,810,520.11	167,718,802.08	104,908,281.97
17	Хаан банк	189,636,413.00	301,657,455.80	112,021,042.80
18	ХасБанк	22,622,660.51	68,133,630.63	45,510,970.12
19	Худалдаа хөгжлийн банк	-	120,312,190.51	120,312,190.51
20	Хүннү сизл	2,795,843.00	3,687,012.27	891,169.27
21	Эм жи ай би	-	1,504,544.00	1,504,544.00
22	Эрсдэлийн шийдэл	519,315,195.70	474,033,280.40	-45,281,915.30
23	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	-	110,487,921.40	110,487,921.40
24	Дэвжих дэлгэрэх холдинг	-	8,960,000.00	8,960,000.00
25	Ар Эм Ай Би	-	-	-
26	Арм интернэшнл	-	-	-
27	Голомт банк	-	-	-
28	Монголиан интернэшнл брокерс	-	-	-
29	Түвшин ориент	-	-	-
30	Цагаан гэрэлт	-	-	-
31	Эс ай би эс	-	-	-
32	Эй Эс Ай Би	-	-	-
33	Эл Би брокерэж	-	-	-
	Нийт	1,239,753,865.34	2,038,149,738.56	798,395,873.22

Тэмдэглэл: - үйл ажиллагаа эрхлээгүй

5.2. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант хугацаанд даатгалын хохирол үнэлгээний үйл ажиллагаа явуулсан компаниуд нийт 5 тэрбум төгрөгийн даатгалын хохирлын хэмжээ бүхий 11317 удаагийн даатгалын хохирлын үнэлгээ хийж, 260.6 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ. Даатгалын хохирол үнэлгээний 50 сая төгрөг ба түүнээс дээш орлого бүхий 2 компанийн орлого салбарын нийт орлогын 44 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт-18

№	Компани	Даатгалын хохирол үнэлгээний орлого		Өсөлт, бууралт
		2014.06.30	2015.06.30	
1	Лэндс	0.00	17,981,000.00	17,981,000.00
2	Хөрөнгө үнэлгээний төв	510,000.00	150,000.00	-360,000.00
3	Ухаашүрт консалтинг	0.00	20,565,454.00	20,565,454.00
4	Итгэлт эстимэйт	25,348,183.00	10,333,638.00	-15,014,545.00
5	Мега марз	5,841,000.00	2,509,000.00	-3,332,000.00
6	Вендо	54,968,727.27	59,870,909.09	4,902,181.82
7	Бэст эстимэйт	11,910,000.00	3,920,000.00	-7,990,000.00
8	Жи эй си си	8,770,909.08	8,663,636.36	-107,272.72
9	Гэрэгэ эстимэйт	46,388,409.00	16,514,951.00	-29,873,458.00
10	Файн эстимэйт	3,887,000.00	0.00	-3,887,000.00
11	Арвижих эстимэйт	18,867,250.00	12,943,363.63	-5,923,886.37
12	Юу Энд Эн	0.00	0.00	0.00
13	Тэгшсонголт эстимэйт	88,000.00	1,382,500.00	1,294,500.00
14	Фэйр валуэшн	7,894,700.00	8,532,500.00	637,800.00
15	Ашид билгүүн	102,271,950.00	55,735,420.00	-46,536,530.00
16	Арга билэг эстимэйт	653,000.00	510,000.00	-143,000.00
17	Хос стандарт	0.00	3,230,000.00	3,230,000.00
18	Сэлэнгэ эстимэйт	2,045,400.00	0.00	-2,045,400.00
19	Капитал эстимэйт	829,000.00	13,151,000.00	12,322,000.00
20	Мастер Үнэлгээ	0.00	17,582,000.00	17,582,000.00
21	Кости эстимэйт	0.00	7,020,000.00	7,020,000.00
	Нийт	290,273,528.35	260,595,372.08	-29,678,156.27

6. ДҮГНЭЛТ, САЛБАРЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улсын арилжааны даатгалын салбарын 2015 оны 2 дугаар улирлын санхүү, даатгалын үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгыг гаргаж, салбарын гол үзүүлэлтүүдийг өмнөх он, сүүлийн жилүүдийн мөн үетэй харьцуулж, дүгнэсэн.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл бүхий даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогч компаниуд дийлэнх нь хэвийн үйл ажиллагаа явуулж, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг “Моннис даатгал” ХХК хувь нийлүүлэгчдийн шийдвэрээр татан буугдсан боловч салбарын санхүү, даатгалын үзүүлэлтүүдийн өсөлтөд төдийлөн нөлөө үзүүлээгүй бөгөөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК тайлант хугацаанд Хорооноос тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь салбарын санхүүгийн үзүүлэлтүүдийн өсөлтөд эерэгээр нөлөөллөө.

Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө 170.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.8 хувиар өссөн нь сүүлийн 5 жилийн өсөлтийн дундаж /31.2%/ хувиас бага байна. Хөрөнгийн бүтцээр нь авч үзвэл эргэлтийн хөрөнгө 83 хувь, эргэлтийн бус хөрөнгө 17 хувийг эзэлж байна. Даатгагчдын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн 52.3 хувийг эзэмшигчдийн өмч, 43.5 хувийг нөөц сан, 4.2 хувийг өр төлбөр эзэлж байгаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад эзэмшигчдийн өмч 45.6 хувиар өссөн нь хамгийн өндөр өсөлтийг үзүүлжээ. Энэ нь Хорооны зүгээс 2017 он хүртэл даатгалын компаниудын дүрмийн санг нэмэгдүүлэх шийдвэр хэрэгжиж байгаатай холбоотой юм. Тайлант улирлын байдлаар даатгалын болон давхар даатгалын компаниудын цэвэр ашиг 3.3 тэрбум төгрөгт хүрч, тухайн үеийн хуримтлагдсан ашиг 5.5 тэрбум төгрөг байна. Энэ улирлын өссөн дүнгээр урт хугацааны даатгагчийн хувьд үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш анх удаа ашигтай ажилласан нь урт хугацааны даатгалын үйл ажиллагаа цаашид идэвхжих нөхцөлийг бүрдүүлж байна.

Даатгалын салбар нь сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж байгаатай шууд хамааралтайгаар салбарын үндсэн үзүүлэлтүүд ч мөн жигд өсөлтийг харуулж байна. Тухайн тайлант хугацааны даатгалын үндсэн үйл ажиллагааны тухайд ердийн даатгалын 16, урт хугацааны даатгалын 4 төрлийн бүтээгдэхүүнээр нийт 36 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий 617925 даатгалын гэрээ байгуулж, 66 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлсэн. Үүнээс даатгалын мэргэжлийн оролцогч болох даатгалын төлөөлөгч 14.6 тэрбум төгрөг, даатгалын зуучлагч 5.3 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг даатгалын компаниудад зуучилсан байна. Салбарын нийт дүнгээр даатгалын нийт хураамжийн орлогын 39 хувь буюу 26 тэрбум төгрөгийг давхар даатгалд шилжүүлэн эрсдэлээ хуваарилж, 0.8 тэрбум төгрөгийн хураамжийг буцаан олгож, 38.3 тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлоготой байна. Тайлант хугацаанд 27312 даатгалын тохиолдолд нийт 20.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ. Үүнээс 64 хувь буюу 13.1 тэрбум төгрөгийг сайн дурын даатгал, 36 хувь буюу 7.3 тэрбум төгрөгийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөрт тус тус олгосон байна.

Даатгагч нарын хохирол нөхөлтийн харьцаа салбарын нийт дүнгээр 48.9 хувь, давхар даатгалыг нэмж тооцсон хохирол нөхөлтийн харьцаа 32.5 хувьтай байгаа тул даатгалын үндсэн үйл ажиллагааг хэвийн гэж үзэх үндэслэлтэй байна. Гэвч зарим даатгалын компаниудын хувьд даатгалын үндсэн үйл ажиллагааны хэвийн түвшин нь дунджаас хазайсан байдал ажиглагдаж байна.

Арилжааны даатгалын олон нийтэд хүрэх хүртээмж, иргэдийн даатгалын боловсролд эерэг нөлөө үзүүлж буй жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар тайлант улиралд 12.9 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж, 7.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосноор өмнөх оны мөн үеэс хураамжийн орлого 24 хувиар, нөхөн төлбөр 20 хувиар тус тус өсчээ. Албан журмын даатгалын хувьд даатгалын хураамжийн орлогын 20 хувь, нийт нөхөн төлбөрийн 36 хувийг эзэлж байгаа нь томоохон үзүүлэлт юм. Салбарын дүнгээр ЖХАЖД-ын

хохирол нөхөлтийн харьцаа 74 хувьтай байгаа нь даатгалын тохиолдлын давтамж, олгож буй нөхөн төлбөр өндөр байгааг илтгэнэ. Энэ нь даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчдод хүртээмжтэй боловч даатгагчдын хувьд хохирол нөхөлтийн харьцаа өндөр гарч байгаа юм.

Тайлант хугацаанд даатгалын зуучлагч 24 компани үйл ажиллагаа явуулж, нийт 2 тэрбум төгрөгийн зуучлалын орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 64.4 хувийн өсөлттэй байна. Мөн даатгалын хохирол үнэлэгч 18 компани 11317 удаагийн даатгалын хохирлын үнэлгээ хийж, 260.6 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ. Даатгалын мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаа идэвхжиж, тогтмол өсөлтийг харуулж буй нь салбарын хөгжил тэр дундаа даатгалын зах зээлийн мэргэжлийн үйл ажиллагааны цар хүрээг тэлж байна.

Даатгалын салбарын санхүү, даатгалын үйл ажиллагааны танилцуулга, үндсэн үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулсан дүгнэлтийг тухайн бүлгүүдэд нь дэлгэрэнгүй тусгасан.

Даатгалын салбарын хяналтын хүрээнд даатгагчдын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, нөөц сангийн хүрэлцээтэй байдлыг хянаж, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд даатгалын шинэ бүтээгдэхүүний гэрээ, даатгуулагчдийн өргөдөл, гомдлыг хянаж, шийдвэрлэж байна. Даатгалын зохицуулалтын газарт бүтээгдэхүүн бүртгүүлэх 18 хүсэлт ирснээс 8 бүтээгдэхүүнийг бүртгэж, хяналт шалгалтын газарт ирсэн 70 өргөдөл, гомдлыг хянаж, шийдвэрлэн даатгуулагчдад 81 сая төгрөгийн нөхөн төлбөрийг даатгалын компаниудаас олгуулсан байна.

Энэ улирлын байдлаар даатгалын салбарын зохицуулалтын хүрээнд 11 журамд өөрчлөлт оруулж, 2 журмыг шинээр батлуулаад байна. Гол зохицуулалтууд нь даатгалын салбарын мэргэжлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, ил тод байдлыг хангах тэр дундаа даатгалын төлөөлөгчдийн орлогын шимтгэлийг ил тод болгох, даатгалын актуарчийн мэргэжлийн үйл ажиллагаанд шалгуур тогтоох, даатгалын салбараас бусад санхүүгийн салбаруудад хөрөнгө оруулалт хийх боломжийг нэмэгдүүлэх зэрэг юм.

Даатгалын зохицуулалтын газрын зүгээс бодлогын түвшинд даатгалын нягтлан бодох бүртгэл, нөөц сантай холбогдох журам, даатгалын мэргэжлийн оролцогчдод тавигдах шаардлага зэргийг боловсронгуй болгох төлөвлөгөөтэй ажиллаж байна.

ДААТГАЛЫН БОДЛОГЫН ХЭЛТЭС